



## НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 14 өдөр

Дугаар А/Н

Улаанбаатар хот

Нийслэлийн оны шилдэг багш,  
дасгалжуулагч, тамирчин, арга  
зүйч шалгаруулах үйл ажиллагаанд  
шаардагдах зардал гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргааны, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйл, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн оны шилдэг багш, дасгалжуулагч, тамирчин, арга зүйч шалгаруулах арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах тайз, лед дэлгэц, хөгжим аппаратур, хөтлөгч түрээслэх гэрээг "Их монгол шувуу" ХХК-тай байгуулан бэлтгэл ажлыг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Спортын хөгжлийн хэлтэс /С.Саранцэцэг/-д даалгасугай.

2. Арга хэмжээнд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

3. Тоног төхөөрөмжийн түрээс, хөтлөгчийн зардалд шаардагдах 2.200.000 /Хоёр сая хоёр зуун мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын  
хорооны даргын 2017 оны 12 дугаар  
сарын 17 ны өдрийн 1 дугаар тушаалын хавсралт



Нийслэлийн оны шилдэг багш,  
дасгалжуулагч, тамирчин, арга  
зүйч шалгаруулах арга хэмжээний  
тайз, хөгжим аппаратур, лед дэлгэц,  
хөтлөгчийн түрээсийн зардлын төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Тайз	600.000
2.	Хөгжим, аппаратур	500.000
3.	Лед дэлгэц	800.000
4.	Хөтлөгч	300.000
ДҮН:		2.200.000

БОЛОВСРУУЛСАН:  
ХЯНАСАН:

С.САРАНЦЭЦЭГ  
О.ЭРДЭНЭЦЭЦЭГ